

2010 ОНЫ ОНЦЛОХ 10 ҮЙЛ ЯВДАЛ


/Монгол улсын Засгийн газрын хуралдаан Гашууны хоолой-2010 он




1. Сүүлийн жилүүдэд орон нутгийн байгалийн баялгийг түшиглэн уул уурхайн хөгжил идэвхжиж, түүнийг даган олон улсын болон улсын чанартай томоохон арга хэмжээд орон нутаг зохион байгуулагдсаны нэг нь “Уур амьсгаар оронлөлт” -ийн асуудлаар Монгол улсын Засгийн газрын хуралдаанд орон нутагт анх удаа өмнөговь аймгийн Баяндалай сумын нутаг “Гашууны хоолой”-д хуралдаж, говийн байгаль экологийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэн Монгол улсын төдийгүй дэлхий нийтийн анхаарлыг хандуулсан чухал арга хэмжээ боллоо.

2. Оюу толгой, Таван толгойн орд газрыг дагасан уул уурхайн олборлолт нэмэгдэхийн хэрээр орон нутгийн өсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ жил бүр өсөн нэмэгдэж, 2010 онд 40,8 тэрбум өгрөгт хүрч, улсын өсөвт төвлөрүүлсэн шилжүүлгийн хэмжээ 31,2 тэрбум төгрөгт хүрсэн нь орон нутаг өөрийгөө бүрэн санхүүжүүлээд зогсохгүй улсын төсөвт хөрөнгө төвлөрүүлдэг цөөхөн аймгийн нэг боллоо.

Орон нутгийн төсвөөс улсын орлогод



Аймгийн өөрийгөө санхүүжүүлэх чадавх



/“Их говийн экологи ба Монгол тэмээ”

симпозиумын нээлтээс /



3. Дэлхийд ховордсон хоёр бхт тэмээ, түүний удмын санг хамгаалах өсгөн үржүүлэх талаар зохион байгуулж байгаа ажлын нэг хэсэг болгон “Их говийн экологи ба монгол тэмээ” сэдэвт Олон улсын симпозиум зохион байгуулан хоёр бхт тэмээний аж ахуйн онцлог, өнөөгийн байдал болон цаашдын зорилт, эдийн засгийн ач холбогдол, тэмээний аж ахуйн тэдгээхүүн, түүхий эдийн ач холбогдлыг хэлэлцлээ. Симпозиумаас цаашид олон улсын үвшинд болон УИХ, Засгийн газрын түвшинд авч хэрэгжүүлэх арга

хэмжээний талаар уриалга гаргалаа. Орон нутгийн төсвөөс 55 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийж аймгийн Музейн салбар “Тэмээний үзэсгэлэн” -ийн шинэ байрыг ашиглалтанд оруулж, 1000 гаруй

үзмэрээр сан хөмрөгийг баяжуулан гадаад дотоодын жуулчид иргэд, хөдөлмөрчид, малчдад үйлчлэх таатай боломж нээгдлээ.

/Санамж бичигт гарын үсэг зурж байгаа нь/

4. Төр-иргэний нийгэм-хувийн хэвшлийн 3 талт хамтын ажиллагааг дэмжиж хөгжүүлэх ажлын хүрээнд 2010 онд аймгийн “Төр, иргэний нийгмийн байгууллага, бизнесийн хамтын ажиллагаа -2011” санамж бичигт 3 тал гарьцсэг зурсан нь төрийн байгууллагын зүгээс иргэний нийгмийн байгууллага, бизнесийн байгууллагатай хамтарч ажиллах, өрийн зарим ажил үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэх зэргээр 3 талт түншлэлийн ажлын уялдаа сайжрах үр дүнтэй ажил боллоо.



/Төрийн байгууллагуудын сахилга хариуцлагын

нэгдсэн зөвлөгөөн -2010 он/



5. Төрийн захиргааны байгууллагын “Сахилга хариуцлагын нэгдсэн зөвлөгөөн”-ийг өргөтгөн зохион байгуулж, төсвийн сахилга, төрийн албаны стандарт хангалт, байгууллагын дотоод хяналтыг сайжруулах талаар хэлэлцэж, зөвлөгөөнөөс төсвийн байгууллага, төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг сайжруулах чиглэлээр албан даалгавар гарган хэрэгжүүлсэн нь төрийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн үр дүнг

сайжруулахад түлхэц боллоо.

6. Аймгийн хэмжээнд 20,0 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийгджээ. Хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээг эх үүсвэрээр нь авч үзвэл: Улсын төсвөөс 10,3 тэрбум, орон нутгийн төсвөөс 8,6 тэрбум, 1,7 тэрбум төгрөгийн гадаадын хөрөнгө оруулалтын ажлууд хийгдсэн байна.



Хүрмэн сумын цэцэрлэг



Ноён сумын цэцэрлэг



Цогт-Овоо сумын соёлын төв



Мандал-Овоо сумын соёлын төв

7. Цогтцэций сумын “Цагаан овоо”, Гурвантэс сумын “Овоот”, Ханбогд сумын “Оюу толгой” зэрэг газруудад нисэх онгоцны буудал шинээр баригдаж, агаарын тээврийн вэмэгдсэнээр зорчигчдын тоо сард дунджаар 800-1200 болж, аймгийн хэмжээнд 4 газарт агаарын тээврийн үйлчилгээ үзүүлж, үйлчилгээ өргөжин хөгжлөө.



“Цогтцэций суман дахь “Тавантолгой” нисэх буудал”



“Эзинис Эрвейз компани орон нутгийн нислэг үйлдэж байна. “

/Ил тод байдал –чанартай үйлчилгээ-2 сарын

аяны нээлт/



8. Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын хэрэгжүүлэх хүрээнд аймгийн ЗДТГ-аас “ Ил тод байдал-чанартай үйлчилгээ” 2 сарын аяныг зохион байгуулж, хяналт тавин биелэлтийг дүгнэж ажилласнаар тогтоолын биелэлт 95,5 хувийн үр дүнд хүрч урьд оноос 6,5 хувиар өссөн байна.

/Сэврэй сумын Хоолт баг/

9. Монгол улсын Засгийн газрын 2008 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Багийн өгжлийг дэмжих” үндэсний хөтөлбөрийг орон нутагт амжилттай хэрэгжүүлж, үйл ажиллагаанд бодит ахиц дэвшил гарлаа. “Багийн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд 2008 онд 554.1 сая, 2009 онд 352,8 сая, 2010 онд 1034,4 сая нийт 1941,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийгдсэнээс улсын өсвөөс 539,0 сая, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 763,6 сая, төсөл хөтөлбөрийн хүрээнд 167,4 сая, хандив тусламжийн хөрөнгөөр 459,1 сая, багийн өөрийн орлогоос 12,2 сая өгрөгийн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажил хийгдсэн байна. Бүтээн байгуулалтын ажлыг төрлөөр нь авч үзвэл: 2008-2010 онд улс, орон нутгийн өсөв, хандив тусламжийн өрөнгө оруулалтаар 19 багийн төвийн цогцолбор барилгыг шинээр



барьж, 15 багийн контор соёлын төвд засвар хийснээр нийт багийн 60,1 хувь буюу 34 багийн контор соёлын төвийг засварлах, шинээр барих замаар багт засаг захиргааны анхан шатны нэгжийн ажиллах, иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх орчин бүрдлээ.

/Мод тарих ажлын хэсгээс-2010 он/



10. Цөлжилт, элсний нүүдлээс хамгаалах зорилгоор 2010 онд 50 га талбайд шинээр ойжуулалт, 50 га талбайд нөхөн сэргээлт, тарьц суулгаж, 2007-2009 онд гэрээгээр мод тарьж ургуулсан иргэдийн гэрээний хэрэгжилтэнд ИНБ-тай хамтран хяналт хийж, нийт 81,2 мянган модонд, 151,1 сая төгрөгийн урамшууллыг олгож, байгаль орчныг хамгаалахад иргэдийн санаачлагыг дэмжин бүх нийтээр мод тарих ажлыг зохион байгуулан 97367 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулж, 79419 ш модыг тарьсан нь улсын хэмжээнд хамгийн олон мод тарьсан аймаг боллоо.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР